



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Шинэжинст сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/50/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор сум 2019 он

Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576

Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024

Цахим хаяг:

tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор:

Г.Ганчимэг

Утас: 88268424

Цахим хаяг: ganaa_7133@yahoo.com

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	8
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.11	Шилэн дансны мэдээлэл	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3.	Менежментийн захидал	10
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	18
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18

Аудитын гэрчилгээ



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail: bayankhongor@audit.gov.mn

ШИНЭЖИНСТ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.БАТХУЯГ ТАНАА

2019.02.25 № 2/89
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын

2519164

систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.АУДИТЫН ТАЙЛАН

2.1 Оршил

Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын дарга Л.Батхуяг-т танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 24-нөөс 2019 оны 02 дугаар сарын 24-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Г.Ганчимэг хариуцаж хэрэгжүүлэв. 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 18-ний өдрийн 11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газар нь мэдлэг чадварт суурилсан мэргэшсэн төрийн захиргааны байгууллага болж, иргэддээ шударга, шуурхай, ил тод нээлттэй үйлчилнэ.

Үйл ажиллагааны чиглэл:

Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Үүнд:

1. **“Баянхонгорын иргэд-Баянхонгорын баялаг”** зарчмыг удирдлага болгож, иргэдээ бүх талаар системтэй хөгжүүлнэ.

2. Жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээг эрчимтэй хөгжүүлэн 20-оос доошгүй иргэнийг тогтвортой байнгын ажлын байраар хангаж, ядуурлыг 2 дахин бууруулна.

3. Боловсролын байгууллагын сургалтын чанарыг сайжруулж, боловсролын чанарын үзүүлэлтийг тэргүүлэх сумуудын хэмжээнд хүргэхийг зорино.

4. Хүний эрүүл мэндэд хортойгоор нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйлсийг багасгаж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг олон улсын жишигт нийцүүлэхийг зорьж, дундаж наслалтыг нэмэгдүүлэх, эрүүл амьдрах таатай боломжийг бүрдүүлсэн эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэх

5. Соёл урлаг, биеийн тамир спорт нь хүний хөгжлийн чухал хүчин зүйл хэмээн үзэж бүх талаар дэмжиж хөгжүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх гэсэн зорилтуудыг тус тус дэвшүүлсэн гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Захиргааны ерөнхий хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг БНА-2019/50/СТА-ТШЗ

алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "Дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь аккрузаль сууриар бэлтгэгдсэн санхүүгийн тайлангийн хувьд дээрх үзүүлэлтийг суурь болгож авах нь зүйтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 558,5 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 11,1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь эрсдлийн үнэлгээ дунд байгаатай холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын төвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын төвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 5 асуудлыг алдаа, зөрчилгүй, 4 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 1 асуудалд аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	7607.1	
2	Төлбөрийн акт тогтоосон	2	1101.4	
	Дүн	4	8708.5	

2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Аудитын явцад Залаажинст торгон сүрэг ХХК-д өвс тэжээл хашаа хорооны засварт 4305.0 мянган төгрөгийг шилжүүлж шууд зардлаар бүртгэсэн, НДШ, ХХОАТ-ын 119.8 мянган төгрөгийг авлагаар тусгаагүй зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

2. Сахилгын шийтгэлтэй 2 албан хаагчид 329.8 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон, мөн сургуулийн захирал, ИТХ-ын нарийн бичгийн дарга үр дүнгийн урамшуулалд 441.6 мянган төгрөг олгосон.

Энэ нь Үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов

2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхэд тавих хяналт хэрхэн хэрэгжиж байгаад дараагийн аудитаар анхаарал хандуулах шаардлагатай.

2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 331,3 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 325,2 сая төгрөг буюу 98,2% -н гүйцэтгэлтэй байгаа нь 4587,7 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 25 мэдээллээс хугацаа хоцорч мэдээлсэн 16, мэдээлэл байна.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт Тамгын газрын даргын 2018 оны 5 дугаар сарын 28 ний өдрийн 75 тоот албан бичгээр хүргүүлж биелэлтийг хангаж ажилласан байна

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг. Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Шинэжинст сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг үзүүлэв. Үүнд:

3.1. Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт

Жилийн эцсийн тооллогын бүртгэл үндсэн хөрөнгийн дэлгэргүй бүртгэлийг тулган шалгахад бусад үндсэн хөрөнгийн дансанд хүний нэрээр орлого авсан 5972,1 мянган төгрөгийн ямар хөрөнгө нь тодорхой бус үндсэн хөрөнгө бүртгэгдсэн байна.

Энэ нь Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдэлд нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.2, Сангийн сайдын 388 дугаар тушаалын 1 хавсралт “нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4,29 дэх заалтыг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл

Тооллого, тооцоог цаг хугацаанд нь хийгээгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж

Төсвийн байгууллагын үйл ажиллагаанд үр дүн бий болж буй үндсэн болон эргэлтийн хөрөнгийг хууль, журам зааврын дагуу бүртгэл тайланд тусгах, өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах, тооллогыг чанартай хийх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Хэрэгжүүлж ажиллана.

3.2 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

3.2.1 Илрүүлэлт:

Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас 1,6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Үнэн зөв байдал батламж мэдэгдэл, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дэх заалтыг тус тус зөрчсөн.

3.2.2 Эрсдэл:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2019.05.15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>88,299,714.01</u>	<u>107,095,197.94</u>
33	АВЛАГА	00.00	4,424,883.94
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	119,883.94
335	Бусад авлага	00.00	4,305,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	4,305,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	88,299,714.01	92,670,314.00
351	Түүхий эд материал	39,368,134.00	39,996,734.00
35110	Тусгай зориулалттай материал	39,368,134.00	39,996,734.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	40,843,000.00	30,871,000.00
354	Хангамжийн материал	7,002,580.01	7,186,580.00
35410	Бичиг хэргийн материал	1,625,250.00	1,589,250.00
35420	Аж ахуйн материал	3,233,180.00	3,453,180.00
35440	Түлш, шатах тослох материал	00.01	00.00
35470	Бусад хангамжийн материал	2,144,150.00	2,144,150.00
35600	Мал амьтад	1,086,000.00	14,616,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	00.00	10,000,000.00
36600	Бусад нөөц	00.00	10,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,302,220,816.69</u>	<u>2,901,024,167.63</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,302,220,816.69	2,901,024,167.63
392	Биет хөрөнгө	2,265,220,816.69	2,764,286,167.63
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,133,159,660.00	3,163,389,248.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,061,645,549.53	-590,476,127.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл	144,534,248.00	137,042,385.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-84,932,080.20	-87,124,325.02
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	182,509,927.50	194,009,387.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-151,815,111.08	-155,976,321.69

Шинэжинст сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	45,349,444.00	57,643,744.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-25,392,287.66	-30,964,239.70
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	2,626,000.00	4,926,000.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	-1,120,533.23	-1,637,233.19
39214	Бусад үндсэн хөрөнгө	109,347,018.13	109,347,018.13
39215	Хуримтлагдсан элэгдэл	-27,399,919.24	-35,893,368.32
393	Биет бус хөрөнгө	37,000,000.00	136,738,000.00
39301	Програм хангамж	600,000.00	600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-600,000.00	-600,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	37,000,000.00	136,738,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,390,520,530.70</u>	<u>3,008,119,365.57</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>216,128.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	216,128.00
413	Өглөг	00.00	216,128.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	216,128.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,390,520,530.70</u>	<u>3,007,903,237.57</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,390,520,530.70	3,007,903,237.57
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	585,141,255.00	684,879,255.00
51101	Өмч: - төрийн	585,141,255.00	684,879,255.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,466,058,205.70	1,475,107,134.38
51210	Өмнөх үеийн үр дүн	1,466,058,205.70	1,466,058,205.70
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	9,048,928.68
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	339,321,070.00	847,916,848.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,390,520,530.70</u>	<u>3,008,119,365.57</u>

1.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	519,951,556.60	567,604,249.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,778,040.60	215,525,666.80
120	Нийтлэг татварын бус орлого	59,778,040.60	215,525,666.80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	59,778,040.60	215,525,666.80
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,925,540.60	186,030.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	43,852,500.00	215,339,636.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	460,173,516.00	352,078,582.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,583,058.00	19,904,680.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,583,058.00	19,904,680.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	273,050,400.00	329,668,185.50
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	273,050,400.00	329,668,185.50
1330	Төсвийн захирагчдаас	162,315,320.00	00.00

Шинэжинст сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

133003	Хөрөнгийн	162,315,320.00	00.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,224,738.00	2,505,717.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,224,738.00	2,505,717.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	534,568,492.32	468,540,032.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	529,568,492.32	468,540,032.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	499,546,693.75	424,971,683.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	174,553,027.57	173,380,657.62
210101	Үндсэн цалин	174,553,027.57	173,380,657.62
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,229,174.03	20,002,043.92
210201	Тэтгэврийн даатгал	18,229,174.03	20,002,043.92
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,392,697.00	14,651,293.00
210301	Гэрэл, цахилгаан	4,302,197.00	1,641,435.00
210302	Түлш, халаалт	8,090,500.00	13,009,858.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,720,089.00	19,123,120.01
210401	Бичиг хэрэг	2,992,380.00	3,218,410.00
210402	Тээвэр, шатахуун	14,552,180.00	14,040,910.01
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,866,800.00	1,366,500.00
210404	Ном, хэвлэл	950,000.00	375,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,732,629.00	122,300.00
210408	Бараа материал акталсны зардал	3,626,100.00	00.00
2105	Нормативт зардал	00.00	422,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	422,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,738,000.00	1,075,000.00
210604	Урсгал засвар	3,738,000.00	1,075,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,585,000.00	6,627,990.00
210702	Дотоод албан томилолт	7,585,000.00	6,627,990.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,098,616.00	15,131,003.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,050,678.00	14,138,410.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	124,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	735,450.00	453,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	292,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	60,305.00
210807	Газрын төлбөр	62,488.00	62,488.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	231,230,090.15	174,558,575.74
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,392,400.00	5,685,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	502,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	191,335,690.15	168,873,075.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,021,798.57	43,568,349.02
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	34,200,000.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	34,200,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,533,038.00	3,585,717.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,224,738.00	00.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	00.00	2,505,717.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,708,300.00	00.00

Шинэжинст сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,600,000.00	1,080,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,780,780.57	5,782,632.02
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,780,780.57	5,782,632.02
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	707,980.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	707,980.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,000,000.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,000,000.00	00.00
223001	Бусад хөрөнгө	5,000,000.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-14,616,935.72	99,064,216.99
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-11,825.52	90,015,288.31
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-11,825.52	2,702,565.97
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	58,040,500.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	29,272,222.34
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	11,825.52	-90,015,288.31
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-14,605,110.20	9,048,928.68

1.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	313,783,736.60	352,264,612.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,925,540.60	186,030.00
120	Нийтлэг татварын бус орлого	15,925,540.60	186,030.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,925,540.60	186,030.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,925,540.60	186,030.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	297,858,196.00	352,078,582.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,583,058.00	19,904,680.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	20,583,058.00	19,904,680.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	273,050,400.00	329,668,185.50
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	273,050,400.00	329,668,185.50
1340	ийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	4,224,738.00	2,505,717.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	4,224,738.00	2,505,717.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	313,783,736.60	352,264,612.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	313,783,736.60	352,264,612.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	283,761,938.03	276,241,963.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	172,939,808.43	175,694,478.12
210101	Үндсэн цалин	155,596,929.43	148,626,073.12
210102	Нэмэгдэл	00.00	4,836,798.00
210105	Гэрээт ажлын хөлс	17,342,879.00	22,231,607.00

Шинэжинст сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,399,476.00	17,591,979.36
210201	Тэтгэврийн даатгал	19,399,476.00	14,097,044.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	897,491.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	627,954.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	61,746.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	1,907,744.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,392,697.00	14,651,293.00
210301	Гэрэл, цахилгаан	4,302,197.00	1,641,435.00
210302	Түлш, халаалт	8,090,500.00	13,009,858.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,716,060.00	19,177,310.00
210401	Бичиг хэрэг	3,061,380.00	3,100,610.00
210402	Тээвэр, шатахуун	14,552,180.00	13,870,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,866,800.00	1,709,000.00
210404	Ном, хэвлэл	970,000.00	375,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	265,700.00	122,300.00
2105	Нормативт зардал	00.00	422,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	422,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,738,000.00	3,848,000.00
210602	Тавилга	00.00	2,300,000.00
210604	Урсгал засвар	2,738,000.00	1,548,000.00
2107	Томилолт, зочны зардал	7,585,000.00	6,627,990.00
210702	Дотоод албан томилолт	7,585,000.00	6,627,990.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,098,616.00	32,319,013.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,050,678.00	31,326,420.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	124,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	705,450.00	453,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	292,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30,000.00	60,305.00
210807	Газрын төлбөр	62,488.00	62,488.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,892,280.60	5,909,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,390,280.60	5,396,200.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	502,000.00	513,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,021,798.57	76,022,649.02
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	66,654,300.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	66,654,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,533,038.00	3,585,717.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	4,224,738.00	00.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	00.00	2,505,717.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,708,300.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,600,000.00	1,080,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6,780,780.57	5,782,632.02
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,780,780.57	5,782,632.02

Шинэжинст сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	707,980.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	707,980.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

1.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 01-р сарын 31-нээрх үлдэгдэл	585,141,255.00	339,321,070.00	1,480,663,315.90	00.00	2,405,125,640.90
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	585,141,255.00	339,321,070.00	1,480,663,315.90	00.00	2,405,125,640.90
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-14,605,110.20	00.00	-14,605,110.20
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	585,141,255.00	339,321,070.00	1,466,058,205.70	00.00	2,390,520,530.70
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	585,141,255.00	339,321,070.00	1,466,058,205.70	00.00	2,390,520,530.70
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	508,595,778.19	00.00	00.00	508,595,778.19
D08	Тайлант үеийн үр дүн	99,738,000.00	00.00	9,048,928.68	00.00	108,786,928.68
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	684,879,255.00	847,916,848.19	1,475,107,134.38	00.00	3,007,903,237.57

1.18.Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	312,391,897.00	278,856,259.00	331,301,700.00	325,266,513.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	312,391,897.00	278,856,259.00	331,301,700.00	325,266,513.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	283,501,697.00	253,035,968.00	262,867,000.00	257,532,213.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	179,224,440.00	172,821,577.00	176,626,300.00	175,694,478.12

Шинэжинст сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210101	Үндсэн цалин	160,947,020.00	153,876,634.00	155,761,100.00	148,626,073.12
210102	Нэмэгдэл	00.00	00.00	00.00	4,836,798.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,277,420.00	18,944,943.00	20,865,200.00	22,231,607.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,614,100.00	19,440,264.00	19,462,100.00	17,591,979.36
210201	Тэтгэврийн даатгал	19,614,100.00	19,440,264.00	19,462,100.00	14,097,044.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	00.00	00.00	897,491.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	00.00	00.00	627,954.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	00.00	00.00	61,746.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	00.00	00.00	1,907,744.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,659,457.00	10,997,364.00	14,628,600.00	14,651,293.00
210301	Гэрэл, цахилгаан	2,959,457.00	2,243,364.00	1,560,000.00	1,641,435.00
210302	Түлш, халаалт	5,700,000.00	8,754,000.00	13,068,600.00	13,009,858.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,684,650.00	17,141,778.00	20,792,300.00	19,177,310.00
210401	Бичиг хэрэг	3,250,000.00	2,082,680.00	3,104,000.00	3,100,610.00
210402	Тээвэр, шатахуун	18,107,050.00	13,424,498.00	13,870,400.00	13,870,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,724,600.00	1,458,600.00	1,817,900.00	1,709,000.00
210404	Ном, хэвлэл	1,603,000.00	176,000.00	1,800,000.00	375,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.00	00.00	200,000.00	122,300.00
2105	Нормативт зардал	800,000.00	800,000.00	461,200.00	422,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	800,000.00	461,200.00	422,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,012,456.00	9,692,000.00	4,048,700.00	3,848,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,175,400.00	3,592,000.00	00.00	00.00
210602	Тавилга	00.00	6,100,000.00	2,300,000.00	2,300,000.00
210604	Урсгал засвар	3,837,056.00	00.00	1,748,700.00	1,548,000.00
2107	Томилолт, зочны зардал	10,798,400.00	7,314,500.00	7,200,000.00	6,627,990.00
210702	Дотоод албан томилолт	10,798,400.00	7,314,500.00	7,200,000.00	6,627,990.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,132,644.00	2,458,675.00	13,787,400.00	13,609,263.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,864,844.00	2,201,995.00	12,417,400.00	12,616,670.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00	250,000.00	124,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	00.00	00.00	500,000.00	453,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	235,800.00	224,680.00	350,000.00	292,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	00.00	00.00	200,000.00	60,305.00
210807	Газрын төлбөр	32,000.00	32,000.00	70,000.00	62,488.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17575550.00	12369810.00	5860400.00	5909900.00

Шинэжинст сумын ЗДТГ 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,671,050.00	12,169,810.00	5,300,000.00	5,909,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,904,500.00	200,000.00	560,400.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28890200.00	25820291.00	68434700.00	67734300.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	00.00	67,254,300.00	66,654,300.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	00.00	67,254,300.00	66,654,300.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,890,200.00	25,820,291.00	1,180,400.00	1,080,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	764,200.00	764,500.00	00.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,326,000.00	25,055,791.00	00.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	600,000.00	00.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	00.00	1,180,400.00	1,080,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	267,096,577.00	265,533,838.00	331,301,700.00	325,266,513.48
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	246,372,200.00	248,339,600.00	314,467,200.00	325,080,483.48
132001	Орон нутгийн төсвөөс	246,372,200.00	248,339,600.00	314,467,200.00	325,080,483.48
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	20,724,377.00	13,652,578.00	16,834,500.00	186,030.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,724,377.00	13,562,578.00	00.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	90,000.00	600,000.00	186,030.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	00.00	00.00	16,234,500.00	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	00.00	00.00	21.00	21.00
620001	Удирдах ажилтан	00.00	00.00	07.00	07.00
620002	Гүйцэтгэх ажилтан	00.00	00.00	11.00	11.00
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00	03.00	03.00